



“Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ-ын захирлын 2025 оны 10 дүгээр сарын 10-ний өдрийн А/60 тушаалын хавсралт

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ЗӨВЛӨМЖИЙГ 2025-2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2026 оны 03 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах нэгж, албан тушаалтан
1	2	3	4	5	6	7
1	Ажилтанд сурах, чадавхи дээшлүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн дэмжлэг үзүүлэх.	Мэргэшсэн зэрэг, гэрчилгээ эзэмшсэн ажилтны тоо	1	5	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Олон улсын төслийн удирдлагын институт (PMI®)-ээс олгодог Мэргэшсэн төслийн удирдагчийн зэрэг (PMP)® олгох шалгалтад 7 албан хаагч бэлтгэсэн бөгөөд байгууллагын зүгээс Пи Эм Ай Монголиа чаптертай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд PMP buddy хөтөлбөрт хамруулсан. Тухайн албан хаагчдад шалгалтад бэлтгэх зорилгоор 14 хоногт нэг удаа цалинтай чөлөө олгон дэмжиж ажилласан бөгөөд 2026 оны 01 дүгээр сарын 23-ны байдлаар зэрэг авсан 5 албан хаагчтай болоод байна. Мөн 3 албан хаагч 2026 онд шалгалт өгөхөөр бэлтгэж байна.

1	2	3	4	5	6	7
2	Төслийн удирдлагын мэдлэг, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт явуулах, чадавхи сайжруулах	Сургалтад хамруулсан ажилтны тоо	-	40	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	“Төслийн менежментийн арга зүй ISO 21500:2021 стандарт”-ын хүрээнд 5 удаагийн сургалт хийгдсэн. 2026 онд төслийн удирдлагын чиглэлээр онол арга зүй, төслийн удирдлагын шинэчлэгдсэн журам, төслийн гүйцэтгэл тайлагналын програм хангамж болон төслийн гэрээний сургалтууд хийгдэхээр сургалтын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан
3	Олон улсын төслийн менежментийн аргачлал (ISO 21500, PMI PMBOK)- ийг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	100 хувь	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	“Төслийн менежментийн арга зүй ISO 21500:2021 стандарт”-ыг нэвтрүүлэх ажлын хүрээнд байгууллагад 4 удаагийн сургалт зохион байгуулагдаж, нийт 22 бичиг баримтыг төслүүдийн ажлын үе шатанд тохируулан боловсруулах ажил хийгдэж байна. Төслийн удирдлагын олон улсын PMBOK аргачлал, стандартад нийцсэн төслийн удирдлагын үйл ажиллагааны журмыг шинэчлэн сайжруулах ажил хийж байгаа бөгөөд 2026 оны нэгдүгээр улиралд багтаан журмыг батлуулахаар ажиллаж байна. Уг журам шинэчлэгдэн баталгаажсаны дараа байгууллагаас хариуцан хэрэгжүүлж буй төслүүдийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд шаардлагатай сургалт, зөвлөгөө, чиглүүлэх ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.

1	2	3	4	5	6	7
Зөвлөмж 2. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулах, батлуулах үе шатуудад аль нэг аж ахуйн нэгж байгууллагад тохируулан боловсруулж давуу байдал олгохоос зайлсхийх.						
4	Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой ажлын даалгавар техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа Ажлын хэсэг байгуулж ажиллах.	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн	Мэргэжлийн байгууллын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулдаг.	Мэргэжлийн байгууллагын төлөөлөлс гадна дотоод, гадаад зөвлөхүүдийн оролцоог хангасан байна.	2026.12.15-ны өдрийг хүртэл	<p>1. Тусгай замын автобус (BRT) төсөл: “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ-ын Захирлын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/65 тушаалын дагуу Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа төслүүдийн нэг болох “Тусгай замын автобус” (BRT) төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг Азийн Хөгжлийн Банкны техник туслалцааны хүрээнд гүйцэтгэж Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан, технологийн дэд зөвлөлөөр дэмжсэний дагуу төслийн Техник, эдийн засгийн үндэслэлд уг дэд зөвлөлөөс ирүүлсэн зөвлөмжийн дагуу сайжруулалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Мөн ажлын хэсгийн нэмэлт даалгавраар “Нарийвчилсан ажлын зургын даалгавар (DED); Үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө (DOD)”-ний ажлын даалгаварт Нийслэлийн харъяа зургаан газраас (НЗДТГ, НТБГ, НЗАА, НЗХГ, ХБХСГ, ЗХУТ) албан бичгээр санал авч ирүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэх ажил хийгдэж байна.</p> <p>2. Улаанбаатар Трам төсөл: Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/1324 дугаар захирамжийн дагуу “Нийтийн тээврийн Улаанбаатар Трам (Хөнгөн галт тэрэг-LRT)” төсөлд бүрэн шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд 2025 оны 10 дугаар сарын 09, 17, 21-ний өдрүүдэд нийт 3 удаа</p>

						<p>хуралдаж, ажлын хэсгийн гишүүдийн өгсөн санал, зөвлөмжийг тусгаж нэгтгэх ажил хийгдсэн.</p> <p>“Улаанбаатар Трам” төслийн хүрээнд Зуслангийн бүсээс Сүхбаатарын талбай хүртэлх чиглэлд 11км, 16 зогсоол, 1 депо бүхий нэгдүгээр шугмыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн талаар зах зээлийн судалгаа хийх, хувийн хэвшлийн түншлэгчийн хөрөнгө оруулалтыг татах, тандан судлаж урьдчилсан үнэлгээний шинжилгээ хийгдэж байна.</p> <p>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/01 тогтоолоор баталсан “Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалт”-д багтсан “Улаанбаатар Трам” төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөө судалгааны дагуу ажил явагдаж байна.</p> <p>“Нийтийн тээврийн Улаанбаатар Трам (Хөнгөн галт тэрэг-LRT)” түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний дүгнэлт дуусаж, 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг даргын зөвлөл, 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ИТХ дахь МАН-ын бүлэг, 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ИТХ-ын АН-ын бүлгийн хуралдаан хуралдаж төр, хувийн хэвшлийн түншлэлээр төслийг хэрэгжүүлэх тогтоолын төсөл дэмжигдсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/586 дугаар захирамжийн дагуу “Нийтийн тээврийн Улаанбаатар Трам (Хөнгөн галт тэрэг-LRT)”-төслийн нэг, хоёрдугаар шугамын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхтэй холбоотой олон улсын банк, санхүүгийн байгууллагатай мэдээлэл, санал солилцох, хамтран</p>
--	--	--	--	--	--	---

<p>ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан.</p>	<p>3. Улаанбаатар Метро: Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" А/1721 дугаар захирамжийн дагуу "Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро"-г барьж байгуулах бүтээн байгуулалтын ажил (Улаанбаатар хот) Багц 1" төсөл арга хэмжээний нээлттэй тендер шалгаруулалтын хоёрдугаар үе шатны тендерийн баримт бичгийг төслийн менежментийн зөвлөх Духуа Инженеринг ХК ба түншлэл боловсруулсныг Ажлын хэсгийн гишүүдэд 12 дугаар сарын 08, 10-ны өдрүүдэд нийт 2 удаа зохион байгуулж, тендерийн баримт бичигт өгсөн санал, зөвлөмжийг тусган ажилласан. Ажлын хэсгийн 12 дугаар сарын 10-ны өдрийн "Ажлын хэсгийн санал, дүгнэлт"-ийг үндэслэн тендерийн баримт бичгийн "бүлэг II.гэрээ, түүний хавсралтад багтах техникийн тодорхойлолтын хэсгийг эцэслэн батлуулсан болно. Батлагдсан тендерийн баримт бичиг, ажлын хэсгийн санал дүгнэлтийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1771 тоот захирамжийг үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 1/1181 тоот албан бичгээр хүргүүлсэн. Төслийн нэгдүгээр шатны шалгаруулалтад тэнцсэн оролцогчдод зориулсан II шат (Багц I)-ны тендерийн баримт бичгийг эцэслэн боловсруулж дуусгаж 2025 оны 12</p>

дугаар сарын 24-ний өдөр ЕРС+F нөхцөлтэйгээр тендерийг зарласан. Тендерийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдөр нээнэ.

4. Шинэ тойрог зам:

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/720 дугаар захирамжаар Улаанбаатар хотын Шинэ тойрог зам төслийн авто замыг шинэчлэх, ТЭЗҮ, зураг төслийг Олон улсын стандартад нийцүүлэх ажлыг хийж гүйцэтгэх, ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Улаанбаатар хотын "Нэгдүгээр тойрог зам" төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах Ажлын даалгавар болон "Шинэ их тойруу" хурдны замын Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах Ажлын даалгавар тус тус батлагдсан.

5. Дүүжин замын тээвэр:

1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/769 дүгээр захирамжийн дагуу "Яармаг Арцат- Өнөр хороолол" чиглэлийн барилга угсралтын ажлын техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний НХААГ/20250103693 зарлалын дугаартай тендер шалгаруулалтыг зохион байгуулж 10 дугаар сарын 20-нд тендерийг нээхэд 2 оролцогч этгээд тендер ирүүлсэн боловч тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.1-д заасан үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн мэргэжлээрээ ажилласан жилийн туршлагын шаардлагыг хангаагүй, зарим шаардлагын мэдэгдэлийг ирүүлээгүй тул тендер шалгаруулалт амжилтгүй болж, 10 дугаар 22-ны өдөр үнэлгээний хорооны гишүүд хуралдаж тендерийг

						<p>дахин зарласан бөгөөд 11 дүгээр сарын 24-ний өдөр нээж, 12 дугаар 01-ны өдөр үнэлгээний хорооны гишүүд хуралдаж, тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн дагуу Максималь ХХК, Гревинг ХХК - иудын түншлэл шаардлага хангасан тул 100% саналтайгаар дэмжигдсэн.</p> <p>2.2025 оны 5-р сард Улсын их хурлын даргын 2025 оны 192 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг төслийн барилга угсралтын ажилтай танилцсан.</p> <p>3.“Дүүжин замын тээврийн барилга болон ажлын зургийг магадлуулах” ажлын хүрээнд зураг төслийг магадлах Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Ажлын зураг, төсвийг 2 үе шаттайгаар магадлуулахаар 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр хүсэлт илгээн 1321/2025 дугаартай барилга байгууламжийн зураг төслийн эхний үе шатны магадлалын дүгнэлтийн нэгтгэл гарсан.</p>
5	Төсөлтэй холбоотой ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичгийг боловсруулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан үнэ, бусад нөхцөл шалгуур шаардлага тавихгүй байх	Шудрага өрсөлдөөний талаар тендерт оролцогчдоос гаргасан гомдлын тоо	0	0	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Төсөлтэй холбоотой ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, тендерийн баримт бичгийг боловсруулахдаа өрсөлдөөнийг хязгаарласан үнэ, бусад нөхцөл шалгуур шаардлага тавиагүй бөгөөд “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ нь Олон Улсын гэрээ хэлэлцээрийн дагуу хийгдэх төсөл хөтөлбөрүүдээс бусад бүх тендерийн сонгон шалгаруулалтын бичиг баримтыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль холбогдох дүрэм журмын дагуу боловсруулж зарладаг бөгөөд Олон Улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хийгдэж буй төсөл хөтөлбөрийн хүрээнд Олон Улсын гэрээнд тусгасан нөхцөлийн дагуу тендерийн бичиг баримтыг боловсруулж зарладаг.

1	2	3	4	5	6	7
	FIDIC-ийн гэрээний хувилбар) орчуулгын ажлын гүйцэтгэлийн хувь	(4 хувилбар	2 хувилбар бүтэн, 2 хувилбар р 70 хувьтай	4 хувилбар 100 хувьтай	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Барилгын үндэсний ассоциаци ТББ-тай байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Гэрээний жишиг нөхцөлийн орчуулга хийх ажлын удирдамж"-ын дагуу Олон улсын инженерүүдийн холбооноос гаргасан (FIDIC) жишиг гэрээний загварыг орчуулах ажлыг эхлүүлсэн. Тайлант хугацааны байдлаар Мөнгөлөг номыг бүрэн орчуулж дууссан. Мөн жишиг гэрээний (FIDIC) нэр томъёоны тодорхойлолтын эхний хувилбарыг боловсруулж гаргасан.
6	FIDIC-ийн гэрээний чиглэлээр туршлага хуримтлуулах, ажилтнуудыг чадавхижуулах	Сайн туршлагын талаарх шинжилгээ тайлангийн тоо	-	Жилд 1 удаа	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-ын Захирлын 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/72 дугаар тушаалаар байгууллагын хэмжээнд төслийн сургамж цуглуулах, нэгтгэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тус тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд алба, хэлтсүүд төслүүдийн үе шат болон байгууллагын үйл ажиллагааны явцад бий болсон сайн туршлага, сургамжийг тодорхойлох зорилгоор нийт 12 удаагийн воркшоп уулзалтыг зохион байгуулж ажилласан. Уулзалтуудын үр дүнд сайн туршлага, сургамжийг системтэйгээр бүртгэн баримтжуулж, байгууллагын хэмжээнд ашиглах боломжтой нээлттэй мэдээллийн санг бүрдүүлсэн. Дээрх 12 удаагийн уулзалтад давхардсан тоогоор нийт 89 албан хаагч хамрагдаж, 61 сайн туршлага,

1	2	3	4	5	6	7
7	Төслийн тендерийн бичиг баримт, гэрээний нөхцөлийг FIDIC жишигт нийцүүлэхтэй холбоотой тулгарч хүндрэлийн талаарх танилцуулагыг дээд шатны байгууллагад хүргүүлэх	Танилцуулга, санал хүргүүлсэн албан бичгийн тоо	-	Жилд 1 удаа	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	<p>199 сургамжийн саналыг тус тус дэвшүүлэн нэгтгэсэн болно.</p> <p>Түүнчлэн байгууллагын 2025 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэх, хуримтлуулсан туршлага, мэдээллийг хуваалцах, цаашдын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал солилцох уулзалтыг Төсөл Дэмжих менежментийн албанаас 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09:00–11:00 цагийн хооронд Хангарди ордны “Б” блокийн 206 тоот өрөөнд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд тус газрын харьяа төслийн нэгжийн гишүүд болон алба, хэлтсийн инженер, мэргэжилтнүүд идэвхтэй оролцож, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, тулгамдсан асуудал, цаашдын сайжруулалтын чиглэлээр санал, санаачилга дэвшүүлэв. Дэвшүүлсэн саналуудыг нэгтгэн, үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлж байна.</p> <p>Төслийн тендерийн бичиг баримт, гэрээний нөхцөлийг FIDIC жишигт нийцүүлэх, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуультай нийцүүлэн боловсруулсан тул одоогийн байдлаар хүндрэл үүссэн асуудал гараагүй байна.</p>

1	2	3	4	5	6	7
8	Олон улсын төслийн менежментийн аргачлал (ISO 21500, PMI PMBOK)-ийг шаттайгаар хэрэгжүүлэх.	Төслийн удирдлагын журам, түүний хавсралт бичиг баримт, процессийн нэвтрүүлэлт	5	50	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Газрын Захирлын 2025 оны А/22 дугаар тушаалаар Төслийн удирдлагын үйл ажиллагааны журам батлагдсан бөгөөд журмын хавсралтаар олон улсын төслийн менежментийн аргачлалд суурилсан төсөлд өргөн хэрэглэгдэх 27 загвар маягтыг батлуулж үе шаттайгаар нэвтрүүлэх ажил үргэлжилж байна. Мөн олон улсын төслийн удирдлагын институт (PMI®) байгууллагын Монгол дахь салбар байгууллагатай хамтран төслийн үе шатны процессын зураглал, төслийн удирдлагын журмыг шинэчлэн боловсруулж батлуулах шатанд үргэлжилж байна.
9	Чанарийн менежментийн тогтолцоо ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлэх.	Сайжруулалтын хувь	-	50	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Байгууллагын үйл ажиллагаанд "Олон улсын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандарт"-ыг нэвтрүүлэх ажлын хүрээнд 14 удаагийн сургалт зохион байгуулагдаж, нийт 26 бичиг баримт боловсруулахаас 24 бичиг баримт бүрэн боловсрууж дуусаад байна. Баталгаажуулалтын ажлыг үе шаттайгаар эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
Зөвлөмж 3.Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТЭЗҮ, магадлалаар баталгаажсан зураг төсөлд үндэслэж, тендер сонгон шалгаруулалтыг зарлаж байх чиглэлийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавих.						
10	Зөвлөх үйлчилгээнд захиалагчийн хяналтыг сайжруулах	Зөвлөхийн гэрээний гүйцэтгэлтэй холбоотой гарсан зөвлөмжийн тоо	-	Жилд 1 удаа	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Монгол Улсын Засгийн газраас "Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан 20 минут хотын бүтээн байгуулалтын төслүүдийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах ажлын хүрээнд Багц 1 "Буянт-Ухаа спорт цогцолбороос Торгоны зам цогцолбор, 120 мянгатын уулзвараас

1	2	3	4	5	6	7
						<p>Сүхбаатарын талбай чиглэлд олон төрөлт нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв боловсруулах УТ2407100001001”, Багц 3 “Зуслангийн бүсийг хотын төвийн бүстэй холбох хөнгөн галт тэрэг (LRT) нэвтрүүлэх төслийн техник эдийн засгийн үндэслэл, загвар зураг төсөв боловсруулах УТ2407100001003” дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг тус тус байгуулсан. Тус байгууллагаас ирүүлсэн тайлантай танилцахад, авто замын сүлжээний хөдөлгөөний эрчмийн судалгаа, Улаанбаатар хотын нийтийн тээврийн судалгаа, трассын дагуух хүн ам зүйн судалгаа, (зорчих хөдөлгөөний зорилгуудыг нарийвчлан авч үзсэн байдал) агаарын бохирдлыг бууруулж нүүрс хүчлийн хийн ялгаруулалтыг багасгах зэрэг тодорхой хэсгүүд нь судалгааны ажлын зорилтот түвшинд хүрэхгүй, хангалтгүй гэж үзэж байгаа тул дахин шинэчлэн сайжруулах, нарийвчлан судалсан ажлыг техник эдийн засгийн үндэслэл ЛТЭЗҮ/-д дэлгэрэнгүй тусгах шаардлагатай тухай 2025.03.18-ны 1/218 дугаартай “Шаардлага хүгээлэх тухай” албан бичгийг Хот төлөвлөлт судалгааны институтд хүргүүлсэн. Мөн тус гэрээний дагуу 2025.07.09 санал хүргүүлэх тухай 1/647, 2025.08.15 Зөвлөмж хүргүүлэх тухай 1/734, тус тус хүргүүлж ажилласан.</p> <p>"Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ нь Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1482 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан ОН2412090014005018 дугаартай гэрээний дагуу "Нийтийн тээврийн Улаанбаатар трам (Хөнгөн галт тэрэг – LRT) төслийн байгаль орчны нөлөөллийн</p>

1	2	3	4	5	6	7
						нарийвчилсан үнэлгээ хийх” ажлыг туслан гүйцэтгэгч Сайхан ариун Дэлхий ХХК-тай хамтран гүйцэтгэсэн. Тус гэрээний дагуу Хот төлөвлөлт судалгааны институтээс ирүүлсэн эхлэлийн тайланг авч танилцан. Манай байгууллагаас “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ”-ний эхлэлийн тайлантай танилцаж, санал, зөвлөмжийг 2026.01.16 өдөр 1/35 албан бичгээр хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
Зөвлөмж 5. Төслийг хэрэгжүүлэхэд газар чөлөөлөлтийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах						
11	Төсөл хэрэгжүүлэх үйл ажилгаатай холбоотой газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналыг хугацаанд нь хүргүүлэх	Хуулийн хугацаанд хүргүүлсэн саналын тоо	1	1	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Нийслэлийн 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тусгуулах саналыг Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу боловсруулж, “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ-ын 2025 оны 1/919 дугаартай албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд цаг хугацаанд нь хүргүүлсэн. Тус газраас
	Хариуцсан төслүүдэд байгаль орчин,	Байгаль орчин нийгмийн нөлөөллийн	0			Байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээ: 1.Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хэрэгжих Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро-г барьж байгуулах төслийн баримт бичиг 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн 12/3400 тоот бүхий Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны ерөнхий үнэлгээний дүгнэлт, ТЭЗҮ болон суурь судалгаа, зураг

12	нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байна.	үнэлгээ хийлгэсэн төслийн тоо	5	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	<p>төсөл боловруулах ажилд мэргэжил арга зүйн зөвлөгөөг БНСУ-ын “Дохуа инженеринг ХК”-ын зөвлөх баг үзүүлж, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн эрх бүхий Эко натур ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан. Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро-г барьж байгуулах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг баталгаажуулсан.</p> <p>2.2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр “Нийтийн тээврийн Улаанбаатар ТРАМ (Хөнгөн галт тэрэг-LRT) төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ОН2412090014005018 дугаар гэрээг нэг талаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нөгөө талаас Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ байгуулсан. Сайхан ариун дэлхий ХХК-тай Хот төлөвлөлт, Судалгааны институт ОНӨААТҮГ ХТСИОНӨААТҮГ/20250203032 тоот зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан Зуслангийн бүсээс Сүхбаатарын талбай, Архивын ерөнхий газраас Сүхбаатарын талбай гэсэн 2 чиглэлд нийтийн тээврийн Улаанбаатар ТРАМ /хөнгөн галт тэрэг-LRT/ төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, тайланг засвартайгаар баталгаажуулах шийдвэр гарсан. Одоогоор баталгаажуулаагүй байна.</p>
----	--	-------------------------------	---	------------------------------	---

						<p>3. “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Усны газар”, “Туул голын сав газрын захиргаа”-ны төлөөлөл оролцсон уулзалтыг 2026 оны 1 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Уулзалтаар Улаанбаатар метро, Улаанбаатар трамвай, Тусгай замын автобус /BRT/, Төмөр зам доогуур авто замын нүхэн гарц барих төсөл, Шинэ тойрог зам, Хөрсний ус, үерийн хамгаалалт, Туул усан цогцолбор зэрэг төслүүдийн талаар дэлгэрэнгүй танилцуулж, бүтээн байгуулалт болон ашиглалтын үе шатанд шаардагдах усны хэрэглээ, ашиглалтыг нарийвчлан тооцох, эх үүсвэрийг түүнтэй уялдуулан тогтоох, усны алдагдлыг багасгах, борооны ус цуглуулахаас эхлээд бохир ус цэвэрлэх хүртэл үнэ цэнтэй, үр дүнтэй усны нөөцийг дахин ашиглах боломжийн талаар хэлэлцэн, санал солилцлоо. “Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төсөл”-ийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын эцсийн шатны тайланг боловсруулах шатанд байна.</p> <p>4. Улаанбаатар хотын тээврийг сайжруулах Тусгай замын автобус BRT төслийн Байгаль орчны ерөнхий үнэлгээний 2025/372 дугаар бүхий дүгнэлтийг Нийслэлийн Байгаль орчны газрын Байгаль орчны үнэлгээ, уур амьсгалын өөрчлөлтийн хэлтсийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Жаргалсайханы гарын үсэг бүхий 2025 оны 10-р сарын 09-ны өдрийн 07/2136 дугаар албан бичгээр ирүүлсэн Үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст тус төслийг Нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэсэн. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг Сэнкоу сольюшн ХХК гүйцэтгэсэн.</p>
--	--	--	--	--	--	--

1	2	3	4	5	6	7
13	Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг батлах.	Захирлын тушаал	-	Шийдвэр гарсан байна	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	<p>Захирлын 2025 оны А/26 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг ажиллаж, Албаны нууцад хамааруулах мэдээллийн жагсаалт болон Төрийн болон албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг гаргаж, биечлэн зөвлөмж авсан. Мөн Тагнуулын ерөнхий газарт 2025 оны 1/913 дугаар албан бичгээр зөвлөмж хүссэн албан бичгийг хүргүүлсэн. Тагнуулын ерөнхий газрын Төрийн нууцын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч П.Амарбаясгалан Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт өөрчлөлт орж буйтай холбоотой түр хугацаанд албаны нууцад хамааруулах мэдээллийг шинээр хүлээн авч шийдвэрлэхгүй. Үүнтэй холбоотой албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт эцэслэн батлагдсаны дараа нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг эцэслэх нь зүйтэй гэсэн хариу зөвлөмжийг утсаар өгсөн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 03/6369 дүгээр албан бичгийн хариу болгож тус байгууллагын 2025 оны 1/949 дүгээр албан бичгээр албаны нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг санал хүргүүлсэн. Одоогийн байдлаар хариу ирээгүй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1454 дүгээр захирамжаар байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн баталсантай холбоотой дээрх жагсаалтыг шинэчлэн хүргүүлэхээр төлөвлөж байна.</p>

Зөвлөмж 6. Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад албаны нууц, мэдээ, мэдээлэлтэй харилцахад гадагш задруулах, хувьдаа ашиглах, бусдад давуу байдал олгохгүй байх, учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх.

1	2	3	4	5	6	7
14	Төрийн болон албаны нууцыг хамгаалах, ашиглах чиглэлээр тодорхой зохицуулалтыг Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлтээр оруулах, нийт албан хаагчдад танилцуулах	Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн баталсан шийдвэр	Хөдөлмөрийн дотоод журмыг захирлы н 2025 оны А/11 тушаалаар баталсан	Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан тушаалын дугаар	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	2.2025 оны А/11 тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн батлахаар 2026 оны А/06 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг хийхээр бэлтгэж байна.
15	Хариуцан хэрэгжүүлж буй төслийн ажлын явц, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил, тод байдлыг хангах	Ил, тод байдлын шалгуур үзүүлэлтийн хувь	85	100	2026.12.1 5-ны өдрийг хүртэл	Төслийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл, олон нийтэд хүргэх үйл ажиллагаа: Нийслэлийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх зорилготой төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, бүтээн байгуулалтын явц, үр дүн, бодит нөлөөллийн талаарх мэдээллийг олон нийтэд үнэн зөв, шуурхай, хүртээмжтэй хүргэх ажлыг системтэйгээр зохион байгуулан ажиллаж байна. 2025 онд хэрэгжиж буй төслүүдийн талаар нийт 14 төрлийн 770 нэгж мэдээлэл, контент бэлтгэн 5 төрлийн сувгаар олон нийтэд хүргэсэн. Тухайлбал: • Үйл явдлын мэдээ -314 • Рийл- 81 • Богино хэмжээний видео танилцуулга- 22 • Бүтээлч контент (2D) -5 • 3D дүрслэл- (төслийн танилцуулга, визуал контент) • Подкаст -8

1	2	3	4	5	6	7
						<p>Дээрх мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас www.ipiu.mn, сошиал сувгууд болох Facebook, Instagram, X (Twitter), YouTube, мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд болон бусад албан ёсны сувгаар дамжуулан түгээж, төслийн явц, үр дүнгийн талаарх бодит, ил тод мэдээллийг олон нийтэд хүргэхэд анхааран ажилласан.</p> <p>Ил тод байдлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:</p> <p>Байгууллагын үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байдлыг хангах, авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.</p> <p>Мөн ил тод байдлыг хангах хүрээнд байгууллагын албан ёсны цахим хуудсанд дараах мэдээллийг тогтмол байршуулж, шинэчлэн олон нийтэд нээлттэй болгосон.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хууль, эрх зүйн баримт бичиг • Санхүүгийн мэдээлэл • Хүний нөөцийн мэдээлэл • Үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө • Нэмэлт шаардлагатай бусад мэдээлэл <p>Олон нийтээс санал, хүсэлт хүлээн авах тусгай цэсийг вебсайтад байршуулж, хариуцсан ажилтан эргэх холбоотой ажиллах тогтолцоог бүрдүүлсэн.</p> <p>Түүнчлэн худалдан авалтын мэдээлэл болон шилэн дансны мэдээллийг олон нийт шууд үзэх боломжийг хангаж, судалгаа, статистик мэдээлэлтэй чөлөөтэй танилцах нөхцөлийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмж, нээлттэй байдлыг нэмэгдүүлэн ажилласан.</p> <p>Нийт төсөв гүйцэтгэлийн 14 төрөл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 6 төрөл, бусад 8 төрлийн нийт 28 төрлийн нийт 157 мэдээллээс хугацаандаа</p>

1	2	3	4	5	6	7
						<p>мэдээллэсэн 151, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцорсон 4 мэдээлэл нийтэд ил тод мэдээллэсэн байна. Мөн Хөрөнгийн болон урсгал зардал, тендер, орлого, зарлага, хандив, батлагдсан төсөв, орон тоо зэрэг мэдээллийг хуульд нийцүүлэн нийтэлсэн.</p>

ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
АЛБАНЫ ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

БОДЛОГО ШИЙДВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Э.ТҮВШИНЖАРГАЛ

Ж.ЛХАГВАСҮРЭН

Б.ЭНХСҮЛД

